



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3.12, 7.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард кредит ББСБ” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 70,000 /далан мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т зөвшөөрсүгэй.

2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ард кредит ББСБ” ХК /Г.Тэлмэн/-д үүрэг болгосугай:

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд улирал тутам ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН